

**БАГАНУУР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 04

Багануур дүүрэг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Багануур дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны 2025 оны жилийн эцсийн тайланд тусгагдсан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцах, судлах түүнд хавсаргасан мэдээ, мэдээллийг ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд: төлөвлөгөөний хэрэгжилт 85 буюу түүнээс дээш хувь “Бүрэн хангалттай”, төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь “Хангалттай”, төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь “Хангалтгүй” гэж тус тус тооцож үнэлгээг гаргав.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны 2025 оны жилийн эцсийн тайланд хамаарах 12 зорилтын 63 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Зорилтын дундаж үнэлгээгээр 96,2 хувь байна. (хүснэгт-2)

(хүснэгт-1)

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1							
	Зорилт 1						100%
1	Арга хэмжээ 1.1						100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2							
	Зорилт 2						100%
2	Арга хэмжээ 2.1						100%
3	Арга хэмжээ 2.2						100%
4	Арга хэмжээ 2.3						100%

5	Арга хэмжээ 2.4					100%
6	Арга хэмжээ 2.5					100%
7	Арга хэмжээ 2.6					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 3						
	Зорилт 3					100%
8	Арга хэмжээ 3.1					100%
9	Арга хэмжээ 3.2					100%
10	Арга хэмжээ 3.3					100%
11	Арга хэмжээ 3.4					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 4						
	Зорилт 4					63,8%
12	Арга хэмжээ 4.1					100%
13	Арга хэмжээ 4.2					44,4%
14	Арга хэмжээ 4.3					47%
Стратеги төлөвлөгөөний зорилго 5						
	Зорилт 5					98,1 %
15	Арга хэмжээ 5.1					100%
16	Арга хэмжээ 5.2 а					100%
	Арга хэмжээ 5.2 б					100%
17	Арга хэмжээ 5.3					96,2%
18	Арга хэмжээ 5.4					0%
19	Арга хэмжээ 5.5					100%
20	Арга хэмжээ 5.6 а					90%
	Арга хэмжээ 5.6 б					96,8%
21	Арга хэмжээ 5.7					100%
22	Арга хэмжээ 5.8					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 6						
	Зорилт 6					100%
23	Арга хэмжээ 6.1					100%
24	Арга хэмжээ 6.2					100%
25	Арга хэмжээ 6.3					100%
26	Арга хэмжээ 6.4					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 7						
	Зорилт 7					50%
27	Арга хэмжээ 7.1					50%
Стратеги төлөвлөгөөний зорилго 8						
	Зорилт 8					100%
28	Арга хэмжээ 8.1 а					0%
	Арга хэмжээ 8.1 б					100%
29	Арга хэмжээ 8.2					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 9						
	Зорилт 9					94,2%
30	Арга хэмжээ 9.1					100%
31	Арга хэмжээ 9.2					100%
32	Арга хэмжээ 9.3					100%
33	Арга хэмжээ 9.4					100%
34	Арга хэмжээ 9.5					71%
Стратеги төлөвлөгөөний зорилго 10						
	Зорилт 10					97,3%
35	Арга хэмжээ 10.1а					92%
	Арга хэмжээ 10.1б					100%
36	Арга хэмжээ 10.2					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 11						
	Зорилт 11					96%
37	Арга хэмжээ 11.1					100%
38	Арга хэмжээ 11.2					71,5%
39	Арга хэмжээ 11.3					100%
40	Арга хэмжээ 11.4					100%
41	Арга хэмжээ 11.5					100%
42	Арга хэмжээ 11.6					100%

43	Арга хэмжээ 11.7					100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 12						
	Зорилт 12					100%
44	Арга хэмжээ 12.1					100%
45	Арга хэмжээ 12.2					100%
46	Арга хэмжээ 12.3					100%
47	Арга хэмжээ 12.4					100%
48	Арга хэмжээ 12.5					100%
49	Арга хэмжээ 12.6					100%
50	Арга хэмжээ 12.7					100%
51	Арга хэмжээ 12.8					100%
52	Арга хэмжээ 12.9					100%
53	Арга хэмжээ 12.10					100%
54	Арга хэмжээ 12.11					100%
55	Арга хэмжээ 12.12					100%
56	Арга хэмжээ 12.13					100%
57	Арга хэмжээ 12.14					100%
58	Арга хэмжээ 12.15					100%
59	Арга хэмжээ 12.16					100%
60	Арга хэмжээ 12.17					100%
61	Арга хэмжээ 12.18					100%

(хүснэгт-2) Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үр дүн;

Д/д	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний тайланд тусгасан дундаж үнэлгээ	Дундаж үнэлгээ
1.	Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгын хүрээнд	1		100%
2.	Спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалах зорилгын хүрээнд	6		100%
3.	Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах	4		93,8%
4.	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлэх	3		63,8%
5.	Үндэсний болон спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ.	8		98,1 %
6.	Иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр			

	тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлэн, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдалтыг нэмэгдүүлж, спортын холбоод, төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулна.	4		100%
7.	Биеийн тамир, спортын байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулна.	1		50%
8.	Хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.	2		100%
9.	Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.	5		94,2%
10.	Хүүхэд залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэх.	2		97,3%
11.	Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчид, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах.	7		96%
12.	Байгууллагын нийтлэг чиг үүргийг хангуулах ажлын хүрээнд	18		100%
Зорилтын дундаж		63		96,2%

(хүснэгт-3) Арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт;

Үнэлгээ	Тоо	Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан үнэлгээний эзлэх хувь	Эзлэх хувь	Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөрүү
85 буюу түүнээс дээш хувь “Бүрэн хангалттай”	56		88,9%	-
70-85 хүртэл хувь “Хангалттай”	2		3,1%	-
70 хүртэл хувь “Хангалтгүй”	3		4,9%	-
0% хэрэгжээгүй	2		3,1%	-
Дүн	63		100%	-

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны 2025 оны жилийн эцсийн тайланд дурдсанаас үр дүн зорилт 1-д нийт 1 арга хэмжээнээс 1 үнэлэгдэж 100 хувьтай, зорилт 2-т нийт 6 арга хэмжээнээс 6 үнэлэгдэж 100 хувьтай, зорилт 3-т нийт 4 арга хэмжээнээс 4 үнэлэгдэж 100 хувьтай, зорилт 4-т нийт 3 арга хэмжээнээс 3 үнэлэгдэж 63,8 хувьтай, зорилт 5-т нийт 8 арга хэмжээнээс 7 үнэлэгдэж, 1 арга хэмжээ нь 0 хувьтай хэрэгжээгүй, 98,1 хувьтай, зорилт 6-т нийт 4 арга хэмжээнээс 4 үнэлэгдэж 100 хувьтай, зорилт 7-т нийт 1 арга хэмжээнээс 1 үнэлэгдэж 50 хувьтай, зорилт 8-т нийт 3 арга хэмжээнээс 2 үнэлэгдэж 100 хувьтай, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, зорилт 9-т нийт 5 арга хэмжээнээс 5 үнэлэгдэж 94,2 хувьтай, зорилт 10-т нийт 3 арга хэмжээнээс 3 үнэлэгдэж 97,3 хувьтай, зорилт 11-т нийт 7 арга хэмжээнээс 7 үнэлэгдэж 96 хувьтай, зорилт 12-т нийт 18 арга хэмжээнээс 18 үнэлэгдэж 100 хувьтай тус тус үнэлэгдлээ.

2025 оны жилийн эцсийн тайлангийн хэрэгжилтийн үнэлгээ 96,2 хувьтай буюу “бүрэн хангалттай” хэрэгжсэн гэж үзэж байна.

85 буюу түүнээс дээш хувь “Бүрэн хангалттай” хүрсэн арга хэмжээ нийт арга хэмжээний 88,9%,/56/-ийг, 70-85 хүртэл хувь “хангалттай” арга хэмжээ нийт 3,1%,/2/, 70 хүртэл хувь “хангалтгүй” арга хэмжээ 4,9 хувийг /3/, “хэрэгжээгүй” 2 арга хэмжээ байна.

Нийтийн биеийн тамирын чиглэлийн хүрээнд биеийн тамирын хэлтэс нь тогтмол хэвшил болгосон аянуудын арга хэмжээнд анхаарч аян тус бүрийн шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд тавьсан тоо баримтыг хангаж ажиллах,судалгааг ямар хугацаанд хийж гүйцэтгэсэн нь тодорхойгүй, биелэлтийг гаргахад зорилтод түвшинтэй уялдуулах, үр дүнгээ тоон баримттай төлөвлөсөн ажлыг сайтар товч тодорхой бичих, иргэдийг идэвхжүүлэх арга хэмжээг байнга авч ажиллах, байгууллагын спорт хамтлагуудийн үйл ажиллагааг тогтмолжуулах, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулах.Цаг үеийн шинж чанартай ажлуудыг төлөвлөгөөний хэрэгжилтэд тусгасан төдий байна. Цаашид байнгын идэвхтэй алхдаг иргэдийн тоон судалгааг тогтмол авч ажиллах, “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийг дүүрэгт зохион байгуулж буй тэмцээнд оролцох иргэдийн тоог нэмэгдүүлэх, хамруулах ажлын бэлтгэлийг сайтар хангахад анхаарч ажиллах, тэмцээний санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллах.

Сайн тал нь дээд байгууллагаас мэргэжлийн албан хаагчдыг байгууллагын спорт хамтлаг хариуцсан ажилтан, арга зүйч нарт жил бүр бие бялдрын түвшин тогтоох сорил авах аргачлалын хэрхэн авч ажиллах талаар мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Биеийн тамирын хэлтсийн дарга цаашид хэлтсийн мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл, арга зүйн зөвлөгөө өгч хугацаатай мэдээ, тайланг хугацаанд нь хянаж баталгаажуулах, мэдээ тайланг гаргахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг үнэн бодитой, иж бүрэн, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв цаг хугацаанд нь нотлох баримтын хамт тайлагнаж хэвших.

Спорт тэмцээний арга хэмжээний чиглэлийн хүрээнд спортын хэлтэс нь 2025 оны спортын тэмцээн, наадмын календарчилсан төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллаж байгаа нь сайн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс харахад Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэх тал дээр хариуцсан мэргэжилтэн анхаарч ажиллах шинэчлэгдсэн хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах, албан бичгээр санал өгөх, дүүргийн Засаг даргад албан бичгээр уламжлах зэрэг ажлыг албажуулах шаардлагатай байна. Хугацаатай ажлуудыг хугацаанд нь хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны 2025 оны жилийн эцсийн тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг үнэн бодитой, иж бүрэн, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв цаг хугацаанд нь тайлагнах. Мөн арга хэмжээний хэрэгжээгүй шалтгааныг тайланд тусгаж хэвших, хийж хэрэгжүүлсэн ажлын төсвийн талаар тодорхой бичиж тусгахыг хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдэд.

“Хангалтгүй” үнэлгээ авсан арга хэмжээнүүдийг анхааралдаа авч, цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, тухайн жилийн зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түвшинг тооцоо судалгаанд үндэслэх, бодитой тодорхой хэрэгжих ажлуудыг төлөвлөж тодорхой зааж өгөх бөгөөд хэрэгжилтийг гаргахдаа суурь түвшин, зорилтот түвшинг сайн анхаарч гаргаагүй, тоо баримтгүй, цаг үеийн шинж чанартай гэж ажилдаа анхаарал хандуулахгүй орхисон, байгууллага аж ахуйн нэгж, спорт хамтлаг, холбоо, клубуудтай уялдаа холбоогүй зэргээс шалтгаалж хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Цаашид хэлтсийн дарга нар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд анхаарч ажиллах, уг ажлыг хийж гүйцэтгэх мэргэжилтнүүдэд удирдлага арга зүйгээр хангаж, биелэлт удааширч байгаа арга хэмжээнүүдэд анхаарч хугацаа болоогүй гэх арга хэмжээнүүдийн бэлтгэл ажлыг хангуулж, чанартай хийж гүйцэтгүүлэхэд анхаарч ажиллах.

Тайланг гаргахдаа хэрэгжүүлсэн арга хэмжээний үйл явц буюу процесс биш шалгуур үзүүлэлтийн дагуу тоон болон чанарын үзүүлэлттэй арга хэмжээг суурь түвшинтэй харьцуулан журамд нийцүүлэн тайлагнахад анхаарах.

Тайланг ирүүлэхдээ хэлтсийн дарга нар баримт бичгийн шаардлага хангуулан гарын үсэг зурагдаж тамга тэмдэг дарж баталгаажуулж ирүүлэх.

Хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана” гэж заасны дагуу тайлагнах.

ХЯНАСАН:ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Г. СҮХБААТАР

Ө. ДАРИЙМАА